



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 57

Жаргалант

Хуулийн хэрэгжилтэд үнэлэлт,
дүгнэлт өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнээр түр ажиллаж байгаа Г.Далайцэрэнгийн “Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулж байгаа ажил, арга хэмжээ, явуулж буй хяналт шалгалтын ажил, үр дүнгийн тухай” тайланг хэлэлцээд үйл ажиллагаагаа эрчимжүүлэх нь зүйтэй байна гэж дүгнэсүгэй.

2.Сумын Засаг дарга Т.Эрдэнэбатад Даалгах нь:

2.1.ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн орон нутагт хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлж ажиллах.

2.2.Сумын ЗДТГын Хүнсний аюулгүй байдал хариуцсан улсын байцаагчийн үйл ажиллагаа явуулах байцаагчийн эрхийг олгуулах асуудлыг холбогдох газарт нь уламжлан шийдвэрлүүлэх.

3.ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Ж.Нямханд/-д Даалгах нь:

3.1.Орон нутаг дунд хугацаанд мөрдөн ажиллах “Хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө”-г 2020 оны 10 дугаар сард багтаан боловсруулж батлуулах.

3.2.Байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт болон иргэдэд Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомжийн талаар сургалт, мэдээлэл хийх, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг улирал бүр зохион байгуулах.

4.Тогтоолын хэрэгжилт үр дүнг тооцож, биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 20-ны дотор ИТХ-д танилцуулахыг ЗДТГ-ын дарга /Г.Нямханд/-д, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын дэргэдэх /Хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлалын хороо/-нд болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Бямбадорж/-д даалгасугай.

ДАРГА

Г. БЯМБАСҮРЭН

D:\Ter togtool.docx